

Компанийн захирлын 20.. оны сарын.....
-ны дугаар тушаалын хавсралт

ШИНЭ АЖИЛТАН СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ / ЗАГВАР

Нэг. Нийтлэг үндэслэл

Энэхүү журмаар /цаашид компани газар гэх/-т ажилд орох мэргэжилтэн, ажилтныг сонгон шалгаруулах үйл ажиллагаатай холбогдсон харилцааг зохицуулна

- Шинэ ажилтан сонгон шалгаруулах журам /цаашид журам гэх/ нь Монгол Улсын үндсэн хууль, /салбарын мэргэжлийн тухай хууль/, Хөдөлмөрийн тухай хууль, Байгууллагын дүрэм, хөдөлмөрийн дотоод журам болон холбогдох бусад хууль тогтоомж эрх зүйн актуудыг үндэслэл болгоно.
- Энэхүү журмын зорилго нь тус компанийн хүний нөөцийг бүрдүүлэх, чадварлаг мэргэшсэн ажилтанг сонгон авч,ажиллуулах, байгууллагын үйл ажиллагааг чанаржуулахад оршино.
- Сул байгаа орон тооны мэдээллийг байгууллагын цахим хуудас, хэвлэл, мэдээллийн хэрэгсэлээр зарлан, сонгон шалгаруулалтыг ил тод, шударгаар явуулна.
- Шинэ ажилтан сонгон шалгаруулах үйл ажиллагаа нь гурван үе шаттай байна.
- Тухайн сул ажлын байрны зар, тавигдах шалгуур, сонгон шалгаруулах журмыг компанийн цахим хуудасанд иргэдэд нээлттэйгээр хүргэнэ.

Хоёр. Сонгон шалгаруулалтанд оролцогчдын бүрдүүлэх материал

- Компанид ажилд орохыг хүссэн иргэн дараах баримт бичгийг бүрдүүлнэ.
- Ажилд горилогчийн анкет
- Ажилд орохыг хүссэн өргөдөл
- Хөдөлмөрийн болон Нийгмийн даатгалын дэвтэр;/ажил эрхэлж байсан бол/
- Урьд ажиллаж байсан байгууллагын тодорхойлолт;
- Иргэний үнэмлэхний хуулбар;
- Мэргэжлийн үнэмлэх, дипломын хуулбар;
- Зэрэг, цолыг тодорхойлсон баримт;
- 3 үеийн намтар;
- Зураг 4 хувь /3x4/;
- Эрүүл мэндийн үзлэгийн дэвтэр;
- Анкет хийх хавтас 1 ш

Гурав. Сонгон шалгаруулалтанд оролцогчдын материалыг хүлээн авах

- Компаниас зарласан ажлын байранд 2.1-д заагдсан материалыг зар олон нийтэд зарлагдсан өдрөөс ажлын 10 хоногийн дотор хүлээн авна.
- Хугацаа хэтэрсэн материалыг хүлээж авахгүй.
- Шаардлага хангаагүй материалыг оролцогчид буцаан олгож цаашдын сонгон шалгаруулалтанд оролцуулахгүй.

Дөрөв. Сонгон шалгаруулалтын зохион байгуулалт

- Сонгон шалгаруулалтын 1-р шатыг хүний нөөцийн алба зохион байгуулж, тэнцсэн иргэний материалыг компанийн захиралд танилцуулна.
- Компанийн захирал тэнцсэн иргэдээс мэдлэг, ур чадварын шалгалт авах товыг тогтооно.
- Мэдлэг, ур чадварын шалгалтын комисс нь дараах бүрэлдэхүүнтэй байна.
 - Дээд дунд шатны менежерүүдийг сонгон шалгаруулах комисст
 - Комиссын дарга :
 - Гишүүд:
 - Тухайн ажилтанг ажиллуулах алба/ хэлтсийн удирдлага
 - Хүний нөөцийн албаны дарга
 - Ёс зүйн хорооны дарга
 - Мэргэжилтэн, ажилтан, дэмжих чиглэлийн туслах ажилтанг шалгаруулах комисст
 - Комиссын дарга:
 - Гишүүд:
 - Тухайн ажилтанг ажиллуулах алба/ хэлтсийн ахлах менежер
 - Хүний нөөцийн албаны дарга
 - Ёс зүйн хорооны дарга
- Томилогдсон комисс нь сонгон шалгаруулалтанд оролцогчдыг нийтлэг болон тусгай шалгуураар үнэлэн сонгоно. Нийтлэг шалгуурт тухайн шалгаруулалтанд оролцогчийн хууль, эрх зүй, харилцааны соёлыг /ярилцлагаар/, гадаад хэлний мэдлэгийг /тестээр/, тусгай шалгуурт мэргэжлийн онолын мэдлэг /тестээр/, ур чадварыг үнэлнэ.

Тав. Сонгон шалгаруулалтыг дүгнэх

- Хүний нөөцийн менежер оролцогчдын шалгаруулалтанд тэнцсэн болон тэнцээгүй тухай мэдээг холбогдох утсаар болон цахим хаягаар шат бүрийн дараа хүргэн, дараагийн шатанд урьж шаардлагатай мэдээллийг хүргэнэ.
- Ажилтан сонгон шалгаруулах комиссын дарга сонгон шалгаруулалт тэнцэн, өндөр оноо авч, эхний 2 байранд тэнцсэн иргэдийг байгууллагын захиралд танилцуулж, эцсийн дүгнэлтийг гаргана.
- Компанийн захирлын дүгнэлтийг үндэслэн, тэнцсэн иргэнд хүний нөөцийн албаны дарга мэдээллийг хүргэнэ.
- Компанийн захирал шалгаруулалтанд тэнцсэн иргэнтэй хөдөлмөрийн гэрээг байгуулснаар сонгон шалгаруулалтын үйл ажиллагаа дуусна.

Зургаа. Бусад зүйл

- Сонгон шалгаруулалтын явцыг баримтжуулсан материалыг хүний нөөцийн менежер архивт дараа оны 1 дүгээр улиралд шилжүүлнэ.
- Сонгон шалгаруулалтын үед гарсан аливаа санал, гомдлыг хүний нөөцийн алба хүлээн авснаас хойш ажлын 1 хоногийн дотор шалгаруулалтын комисс шийдвэрлэнэ. Ойлголцолд хүрээгүй тохиолдолд байгууллагын удирдлагын багийн хурлаар хэлэлцэн шийдвэрлэж, гомдол гаргагчид бичгээр мэдээлнэ.